Хүний нөөцийн хөгжлийн систем – ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТАД ОРОЛЦОГЧИЙН ХУРААНГУЙ ЗААВАР

Системд хандах линк:

http://hr.hdc.gov.mn/

Бүртгэлтэй хэрэглэгч:

Хэрэв өмнө нь бүртгүүлсэн бол
"Нэвтрэх нэр"- хэсэгт регистрийн дугаар

"Нууц үг" – Өөрийн бүртгүүлэхдээ үүсгэсэн нууц үгийг оруулах.

Бүртгүүлэх товч дарж бүртгүүлэх хуудас руу шилжинэ.

Шинэ хэрэглэгч та **Заавар харах** дарж заавартай танилцана уу /Нэвтэрсний дараа "Тусламж" цэснээс бусад заавартай танилцаарай/

БҮРТГЭЛ ҮҮСГЭХ ХУРААНГУЙ ЗААВАР

1. http://hr.hdc.gov.mn/ хаягаар нэвтэрч “Бүртгүүлэх” дарж бүртгүүлнэ /бүртгэлтэй бол дахин бүртгүүлэхгүй/
2. “Регистрийн дугаар”, “Эцэг эхийн нэр”, “Өөрийн нэр”, “Утасны дугаар”, “И-мэйл хаяг” /өөрийн ашиглагддаг хаягаа оруулах- нууц үгээ мартсан тохиолдолд регистр, бүртгэлтэй и-майл хаягаар хүсэлт гарган шинэ нууц үгээ и-мэйл хаягаар авна/, “нууц үг”, “нууц үг баталгаажуулах” /өөрийн мартахгүй байх нууц үг зохиож үүсгэнэ/ зэрэг талбарыг Монгол хэлээр алдаагүй бөглөж, “үйлчилгээний нөхцөл” хэсгийг чагталсны дараа БҮРТГҮҮЛЭХ товчийг дарж бүртгүүлнэ.
3. НЭВТРЭХ товчлуур дарж нэвтрэх нэр хэсэгт өөрийн регистрийн дугаар, нууц үг хэсэгт өөрийн зохиосон нууц үгийг бичиж системд нэвтрэн орно.
4. Баруун дээд хэсэгт байх өөрийн нэр дээр дарж “Миний мэдээлэл” хэсгийг сонгож нээнэ.
5. “Ерөнхий мэдээлэл” хэсэгт байх “Мэдээлэл шинэчлэх” товчийг дарснаар таны мэдээлэл ХУР системээс баталгаажин ногоон өнгөтэй болно. /Жич: овог нэрийг алдаатай эсвэл латинаар бичсэн, бичиж дуусаад зай авсан тохиолдолд ХУР системтэй таарахгүй болно/
6. Программ дахин нэвтрэн орж бөглөгдөөгүй талбарын мэдээллийг бүрэн бөглөнө. /цээж зураг хэсэгт албан ёсны эгц өөдөөс харсан, албан хувцастай зураг оруулна/
7. “Мэргэжил” гэсэн цонхыг дарж “Мэргэжил”, “Дипломын дугаар”, “Тушаалын огноо”/захирлын тушаал/, “Зардлын хэлбэр”, “Төгссөн сургууль” зэргийг сонгож хавсралт хэсэгт өөрийн дипломыг дүнгийн хавсралтын хамт **PDF** хэлбэрээр оруулж хадгална. /Монгол тал байхад болно/
8. Үндсэн болон төрөлжсөн, мэргэжил дээшлүүлэх сургалтаа мөн адил талбар бүрийн ард байх **+ товч** дарж бөглөнө.
9. Ажлын туршлагаа бөглөж, нотлох баримыг PDF-ээр хавсаргана /Өмнөх ажилласан туршлагаа бүрэн оруулна/
10. Таны ажлын туршлагыг танай ажил олгогч байгууллагын хүний нөөц баталгаажуулах үүрэгтэй.
11. Уг бүртгэл нь зөвхөн нэг удаа үүсгэх бөгөөд цаашид өөрчлөлтийн мэдээллээ оруулаад явна.
12. “**Ерөнхий мэдээлэл**”, “**Мэргэжил**”, “**Ажлын туршлага**” , “**Мэргэжлийн зэрэг**” бөглөөгүй бол үйлчилгээ авах боломжгүй.

Бүртгэл үүсгэх дэлгэрэнгүй заавартай танилцаарай

- **Шалгалтад бүртгүүлэх**
- Хувийн бүртгэлээр нэвтрэн “Зарлал”, “Шалгалтын зар” хэсгийг дархад өөрт хамааралтай шалгалт гарч ирнэ /Зарлал харагдахгүй бол бүртгэлийн заавартай танилцаж мэдээллээ бүрэн бөглөнө/. Шалгалтын бүртгэл зарласан хугацаанд явагдахыг анхаарна уу.
- Өгөх шалгалтын нэр дээр дархад **БҮРТГҮҮЛЭХ** гэсэн ногоон товч гарч ирнэ. Товчлуур дээр дарснаар таны шалгалтын хүсэлт илгээгдэн ногоон товч **Бүртгэл баталгаажтал түр хүлээнэ үү** гэж өөрчлөгдөнө.
- Шалгалтын хүсэлтээ илгээсэн бол бүртгүүлэх хугацаа дуусахаас өмнө шалгалтын төлбөрөө төлнө.
  - Шалгалтын төлбөр 12,000 төгрөг /илүү, дутуу төлөлттэй баримт хүлээн авахгүй/
  - Хүлээн авах банк: Төрийн сан
  - Хүлээн авах байгууллага: Эрүүл мэндийн хөгжлийн төв
  - Зориулалт буюу утга: Шалгалтын төлбөр /Овог, нэр, регистрийн дугаар/
  - Дансны дугаар 100900020020 /Банкаар болон интернет банк, ЭМХТ-ийн I, II-дугаар байрны нэг давхарт төлж болно/
- Шалгалтын өмнө санхүүгийн тулгалт хийн бүртгэлийг нэгдсэн байдлаар баталгаажуулахад **Бүртгэл баталгаажтал түр хүлээнэ үү** товч **Шалгалт өгөх** болж өөрчлөгдөнө.

Шалгалт өгөх

- Заасан хугацаанд хувийн бүртгэлээрээ нэвтрэн орж “Шалгалтын зар” хэсэгт ороход **Шалгалт өгөх** гэсэн цонх байна. /Мөн илгээмж хэсгээс дамжин орж болно/. Шалгалт товлосон хугацаанд явагдах тул хоцрохгүй орохыг зөвлөж байна.

Зөвшөөрлийн хүсэлт гаргах

- Шалгалтад тэнцсэн бол “Миний мэдээлэл”-ийн “Лицензэ” хэсгээс шалгалтад тэнцсэн үнэлгээгээ ашиглан лицензийн хүсэлт илгээнэ.
- **“Дүйцүүлэх материал”** хэсэгт тэмдэгтийн хураамж төлсөн баримтаа харгалзах сонголтод оруулна /Хүний их эмч 2 жилийн лиценз 10000 төгрөг, бусад эмнэлгийн мэргэжилтэн 5000 төгрөг/. Тэмдэгтийн хураамжийг Банкаар болон интернет банк, ЭМХТ-ийн I, II-дугаар байрны нэг давхарт төлж болно.
- Лицензийг үнэт цаасаар хэвлэх тул ажлын 5 өдөрт багтаан цээж зургаа ЭМХТ-ийн 2 дүгээр байрны 212 тоотод авчирч өгнө. /овог нэр, регистерийн дугаар, утасны дугаараа гаргацтай бичиж явуулах/. Шуудангаар илгээж болно.

Хүний нөөцийн хөгжлийн систем – ЗӨВШӨӨРЛИЙН ШАЛГАЛТАД ОРОЛЦОГЧИЙН “4 алхамт” ЗААВАР

Системд хандах линк:

http://hr.hdc.gov.mn/

Бүртгэлтэй хэрэглэгч:

Хэрэв өмнө нь бүртгүүлсэн бол
“Нэвтрэх нэр”- хэсэгт регистрийн дугаар

“Нууц үг” – Өөрийн бүртгүүлэхдээ үүсгэсэн нууц үгийг оруулах.

Бүртгүүлэх товч дарж бүртгүүлэх хуудас руу шилжинэ.

Шинэ хэрэглэгч та **Заавар харах** дарж заавартай танилцана уу /Нэвтэрсний дараа “Тусламж” цэснээс бусад заавартай танилцаарай/

АЛХАМ НЭГ:

СИСТЕМД БҮРТГЭЛ ҮҮСГЭХ

АЛХАМ ХОЁР:

ШАЛГАЛТЫН ХҮСЭЛТ ИЛГЭЭХ

АЛХАМ ГУРАВ:

ШАЛГАЛТ ӨГӨХ, ҮР ДҮНГ ХАРАХ

АЛХАМ ДӨРӨВ:

ЛИЦЕНЗИЙН ХҮСЭЛТ ӨГӨХ

www.hr.hdc.gov.mn

АЛХАМ НЭГ:

“Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэл мэдээллийн сан”-д СИСТЕМД БҮРТГЭЛ ҮҮСГЭХ

www.hr.hdc.gov.mn

Хэрэглэгч - Системд бүртгүүлэх

1. Иргэншил: Сонгох

3. Эцэг/эхийн нэр: Овог оруулах

4. Өөрийн нэр: Хэрэглэгчийн нэр

5. Утасны дугаар: Тоогоор оруулах

6. Имейл хаяг: Нууц үг солих, мэдээлэл илгээх тул заавал зөв хаяг оруулах

8. Үйлчилгээний нөхцөл зөвшөөрөх : Үйлчилгээний нөхцөлтэй танилцаад **Зөвшөөрсөн** тэмдэглэгээтэй болгох.

2. Регистрийн дугаар:
Регистрийн дугаар оруулна.

Нэвтрэх нэр нь цаашид регистр байна.

7. Нууц үг :
5-с дээш орон бүхий тоо, үсэг, тэмдэгт оролцуулан үүсгэх
Нууц үг баталгаажуулах:
Үүсгэсэн нууц үгийг давтан оруулна

9. "**Бүртгүүлэх**" товч дарснаар бүртгэл амжилттай болсныг харуулах цонхонд шилжилнэ.

© 2021. Health Development Center - All rights reserved.

Системд бүртгүүлэх – **Амжилттай бүртгэгдлээ !**

1. Таны бүртгэл амжилттай болсон бол зураг дээрх хуудас харагдана.

Системд нэвтрэх нэр
Таны бүртгүүлсэн регистрын дугаар нь системд нэвтрэх нэр болохыг анхаарна уу!

Нэвтрэх нэр нь цаашид **регистрийн дугаар** байна.

"**Нэвтрэх**" товч дарж нэвтрэх хуудсанд шилжилнэ үү.

Хэрэглэгч - Системд нэвтрэх

Зураг1

1. Нэвтрэх нэр: Бүртгүүлэхдээ оруулсан таны **регистр**

2. Нууц үг: Бүртгүүлэхдээ үүсгэсэн нууц үгийг оруулах

"**Нэвтрэх**" товч дарснаар системд нэвтэрнэ.

зураг2

Амжилттай нэвтэрсэн бол та дээрхи зурагт харуулсан хуудсанд шилжсэн байх болно.

Амжилтгүй *Хэрвээ нэвтэрч чадаагүй бол хэрхэн нууц үг сэргээх тухай дараагийн хуудсанд тайлбар оруулав.*

Хэрэглэгч - Нууц үгээ мартсан, Нууц үг сэргээх

Зураг 1

Системд нэвтэрч чадаагүй бол **Зураг 1-т** харуулсан Анхааруулга харагдана. -Та нэвтрэх нэр (регистрийн дугаар), нууц үгээ шалгаад дахин оролдоно уу.

Та нууц үгээ мартсан бол **"Нууц үг сэргээх"** товч дарж бүртгэлтэй регистр, и-мейл хаягаа оруулж и-мейлээр шинэ нууц үгээ авна уу

Зураг 2

Зураг 2

1. Регистрийн дугаар:
Бүртгүүлэхдээ оруулсан таны **регистр**

2. И-мейл хаяг:
Бүртгүүлэхдээ оруулсан и-мейл хаягаа бичих

Дээрхи талбаруудыг бөглөөд "**Илгээх**" товч дарснаар таны и-мейл хаягруу нууц үг илгээгдэнэ. Ирээгүй тохиолдолд та Spam-аа шалгана уу

Миний мэдээлэл – Ерөнхий мэдээлэл – Нууц үг солих

Системийн аюулгүй байдал, хөндлөнгийн нөлөө орохоос сэрэмжлэн **бусдаар нээлгэсэн болон сэжигтэй тохиолдолд НУУЦ ҮГИЙГ СОЛИНО уу.** Нууц үг солиогүйгээс гарсан аливаа эрсдлийг ЭМХТ хариуцахгүй болохыг үүгээр мэдэгдэж байна. Таны нууц үг зөвхөн таны өмч байх ёстой.

Нууц үгийг солих нүдийг дарахад Зураг 2-т харуулсан талбар нээгдэх ба талбаруудыг бөглөөд **Солих** товч дарснаар солигдоно.

Амжилттай нэвтэрлээ – **Миний мэдээлэл**

Компьютерээс хувийн мэдээлэл оруулах

1. Баруун буланд харагдах өөрийн нэр дээр дарах
2. Миний мэдээлэл цэс дээр дарснаар миний мэдээлэл хуудсанд шилжинэ

Гар утас, бусад хэрэгслээс хувийн мэдээлэл оруулах

3. тэмдэг дээр дарах
4. тэмдэг дээр дарж миний мэдээлэл цэсийг сонгон Миний мэдээлэл хуудаст шилжинэ

Зааврын дагуу нэвтрэхэд таны хувийн мэдээллийг агуулсан цонх нээгдэнэ

Зарлал цэс:
Өөрт хамаарах, шалгалт, сургалт, ажлын зар бусад мэдээлэлтэй танилцана.

Тусламж цэс:
Систем ашиглах заавруудтай танилцана.

Миний мэдээлэл – Ерөнхий мэдээлэл

1. Гэрийн хаяг:
Аймаг/Нийслэл сонгох
Сум/Дүүрэг сонгох
Баг/Хороо сонгох
Гэрийн хаяг хэсэгт Хашаа/Байр, тоот хаяг бичиж оруулах.

2. Ургийн овог :
Өөрийн ургийн овгийг оруулах

3. И-мэйл хаяг:
Та нууц үг сэргээх, мэдээлэл авах зэрэгт ашиглах тул и-мэйлээ шалгаж **алдаатай бол заавал** засаарай

4. Гэр бүлийн мэдээлэл:
➕ - нэмэх товч дарахад мэдээлэл оруулах хүснэгт нэмэгдэнэ. Асуултын дагуу бөглөнө.

5. Та өөрчлөлт хийсэн, мэдээлэл оруулсан бол **ХАДГАЛАХ** товч дарна уу.

Регистрийн дугаар овог нэрийг ХУР системээр баталгаажуулахад алдаат гарсан бол улаан хүрээтэй байна.
Мэдээлэл шинэчлэх товчийг дарж засна уу /баталгаажихгүй тохиолдолд дахин шинээр бичиж болно/.

Миний мэдээлэл – Мэргэжил | Мэргэжил нэмэх

1. Мэргэжил, үндсэн мэргэшил, төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтын харгалзах + - товчийг дараад **Зураг 2**-т харуулсан цонх нээгдэх ба утгуудыг бөглөж, сонгоод Хадгалах товч дарснаар мэргэжил нэмэгдэнэ.

Зураг 2

Дипломын хуулбар, дүнгийн хавсралт /гадаадад төгссөн бол баталгаат орчуулгын хамт/-ыг аттачилана.

2. Мэргэжил: Эзэмшсэн мэргэжлээ сонгох
Тушаалын дугаар : Тушаалын дугаар оруулах /мэргэжилд *заавал биш*/
3. Тушаалын огноо: Тушаал гарсан огноог оруулах
4. Зардлын хэлбэр: Хувийн | Улсын | Төсөл, хөтөлбөрийн гэсэн 3 сонголтоос сонгох
5. Суралцсан улс: Мэргэжил эзэмшсэн улсаа сонгох
6. Байгууллага: Байгууллага сонгох /хэрэв гадаадад мэргэжил эзэмшсэн бол бичиж оруулах боломжтой./
7. Хавсралт: Таны мэргэжлийг нотлох хуулбар баримтыг PDF-ээр оруулах.
8. Дээрхи мэдээллүүдийг оруулснаар **Хадгалах** товч дарж таны мэдээлэл хадгалагдана.

Бөглөсөн мэдээллийн дагуу зөвхөн таны мэргэжил, мэргэшилтэй хамааралтай мэдээлэл харагдах тул мэргэшсэн байдлаа бүрэн бөглөнө үү

Миний мэдээлэл – Мэргэжил | мэргэжил нэмсэн

Зар таны мэргэжлийн чиглэлээс хамааран хязгаарлалттай хүрэх тул Боловсрол хэсэгт мэргэжлийн мэдээллээ бөглөсөн ч гэсэн үйлчилгээ авахын тулд энэ самбарын мэдээллийг **заавал бөглөнө**.

Мэргэжил, Үндсэн, Төрөлжсөн мэргэшил нэмсний дараах байдал.

АЛХАМ ХОЁР:

“Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэл мэдээллийн сан”-д ШАЛГАЛТЫН ХҮСЭЛТ ИЛГЭЭХ

www.hr.hdc.gov.mn

Зарлал – Шалгалтын зар / Шалгалтанд бүртгүүлэх

Шалгалтанд бүртгүүлэх

Хувийн мэдээлэл цэс дээр мэргэжил оруулсан хэрэглэгчид тухайн мэргэжлийн шалгалтын зар нь Зарлал –> Шалгалтын зар цэс дээр харагдах болно.

Хувийн мэдээлэл -> Мэргэжил хуудсанд мэргэжил нэмээгүй бол шалгалтын зар харагдахгүй.

Тест шалгалт

1. Шалгалтын нэр дээр дарж “Шалгалтын ерөнхий мэдээлэл” цонх руу шилжилнэ

Бүртгүүлэх

2. “Шалгалтын ерөнхий мэдээлэл”-ыг нягтлаад таны өгөх шалгалт мөн бол **бүртгүүлэх** товч дээр дарснаар дараах шалгах цонх нээгдэнэ. **3.** **Ок** дарснаар таны хүсэлт илгээгдэнэ.

Зарлал – Шалгалтын зар / хүсэлт илгээгдсэн. Илгээмж

Шалгалтад бүртгүүлэх Хүсэлт

Амжилттай илгээгдсэн бол хүсэлт илгээх товч идэвхигүй болох ба хүсэлтийг АДМИН хэрэглэгч таны төлбөрийн баримтыг үндэслэн бүх оролцогчдийг **нэгдсэн** байдлаар баталгаажуулах хүртэл түр хүлээнэ үү.

Шалгалтын үргэлжлэх хугацаа : 100 минут

Шалгалтын төлбөр: 12000₮

Илгээмж

Шалгалтад бүртгүүлэх хүсэлт баталгаажсан бол хэрэглэгчийн илгээмж цэсэнд илгээмж ирсэн байх ба илгээмж дээр дарж шалгалтруу орж болно.

Шалгалтанд бүртгүүлэх хүсэлт илгээсэн бол та төлбөрөө төлсний дараа таны хүсэлт баталгаажихыг анхаарна уу!
Шалгалтын төлбөр 12,000 төгрөг /илүү, дутуу төлөлттэй баримт хүлээн авахгүй/
Хүлээн авах банк Төрийн сан
Дансны дугаар 100900020020 /Төлбөрийг банкаар болон интернэт банк, ЭМХТ-ийн нэг давхарт автомат машинд төлөх боломжтой/
Хүлээн авах байгууллага Эрүүл мэндийн хөгжлийн төв
Зориулалт буюу утга: Шалгалтын төлбөр /Овог, нэр, регистрийн дугаар/

АЛХАМ ГУРАВ:

“Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэл мэдээллийн сан”-д ШАЛГАЛТ ӨГӨХ, ҮР ДҮНГ ХАРАХ

www.hr.hdc.gov.mn

Шалгалтын зар – Шалгалт өгөх

Шалгалт өгөх

Шалгалтын бүртгэл дуусах хугацаа

Шалгалт авах огноо: 2021-07-09 14:51 цагаас байгаа тул шалгалт тухайн цагт эхэлнэ.

Шалгалт өгөх – товч дээр дарж шалгалт өгөх хуудсанд шилжинэ.

Шалгалт өгөх гэж ороход цаг болоогүй бол шалгалтын хуудас нээгдэхгүй ба эхлэх хугацааны мэдээлэл харагдана.
Хугацаа болсны дараа шалгалт эхлэхгүй тохиолдолд хуудсыг дахин /Refresh/ ачааллана уу.

Шалгалтын зар – Шалгалт өгөх

Шалгалт эхлэхэд дараах цонх нээгдсэн байна.

- Хариулт бөглөсөн асуултын дугаар **ногоон** өнгөтэй болно /Энэ хэсэг гар утас зэрэг жижиг төхөөрөмж дээр харагдахгүй болно/.
- Асуултын харгалзах хариулт дээр дарснаар зурагт харуулсан шиг хариултын өнгө **цэнхэр** болно.

Бүх асуултын хариултыг сонгосон бол Хамгийн дор байрлах **Дуусгах** товч дээр дарж шалгалтыг дуусгана.

- Шалгалтыг дуусгаснаар үр дүн шууд харагдана.
- Интернетийн дата эрх дуусах, цэнэг дуусах зэрэг таны төхөөрөмжөөс хамааран шалгалтаа дуусгаж чадаагүй бол ЭМХТ хариуцлага хүлээхгүй.
- hr.hdc.gov.mn сайт, шалгалттай холбоотой асуудлаар ЭМХТ-ийн 11461529 утсанд хандана уу

Хувийн мэдээлэл – Шалгалтын түүх

Шалгалт өгсөн хэрэглэгч шалгалтын түүх харах бол

Минийн мэдээлэл -> Шалгалт цэс дээр дарж **Системийн шалгалт** хүснэгтээс систем дээр өгсөн шалгалтын үр дүн, өгөх шалгалтын мэдээллийг харах боломжтой.

Үүнд :

- Шалгалтын нэр
- Төрөл
- Дэд төрөл
- Авсан оноо
- Босго оноо
- Тэнцсэн эсэх
- Огноо

Системийн бус шалгалт

Цахимаар бус танхимаар өгсөн лицензтэй холбоотой шалгалтуудын бүртгэлийг нэмэх товч дарснаар мэдээлэл оруулах цонх нээгдэхэд харгалзах мэдээллүүдийг бөглөж хадгалах дарснаар бүртгэл үүснэ.

Системийн бус шалгалтын үр дүн нэмэх бол сүүлийн хуудсанд тайлбар оруулав.

Системийн шалгалт

Цахим шалгалтын дүнгийн мэдээлэл автоматаар орно.

АЛХАМ ДӨРӨВ:

“Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэл мэдээллийн сан”-д ЛИЦЕНЗИЙН ХҮСЭЛТ ӨГӨХ

www.hr.hdc.gov.mn

Лиценз| Шалгалтаар лицензийн хүсэлт илгээх.

Алхам 1.

Миний мэдээлэл – Лиценз хэсэгт дарж орно.
Лицензийн хүсэлт илгээх товч дарна.

Алхам 2.

Лицензийн хүсэлт илгээх цонх нээгдэх ба **Шалгалт** товчийг дарна.

Лиценз| Шалгалтаар лицензийн хүсэлт илгээх. /үргэлжлэл/

Алхам 3.

1. Лицензийн төрөл: Сувилах| Сэргээн засах | Эм барих | Эмчлэх | Эх барих – төрлүүдээс сонгоно.
2. Лицензийн дэд төрөл: Бага эмч| Нүүр ам судлалын хүний их эмч | Уламжлалт анагаах ухааны бага эмч | Уламжлалт анагаах ухааны хүний их эмч
3. Системийн бус шалгалт: Та өөрийн оруулсан мэдээллээ сонгоно.
4. Системийн шалгалт: Өгсөн системийн шалгалтыг сонгоно.

Та дээрхи 2 шалгалтын төрлийн аль нэгийг сонгох боломжтой.

5. Хүсэлт илгээх: Дээрхи мэдээллүүдийг сонгоод хүсэлт илгээх товчыг дарснаар баталгаажуулах цонх нээгдэх ба 6. ОК дарснаар илгээгдэнэ. /**Зураг 2**/

Лиценз| Шалгалтаар лицензийн хүсэлт илгээгдлээ.

Таны хүсэлтийн Хүлээн авсан, Татгалзсан гэсэн үндсэн төлвүүдтэй болох болно.

Админаас хүсэлтэд хариу өгсөн бол илгээмж ирэх ба дарж ороход төлөв солигдсон байх болно./**Зураг 2**/

Таны хүсэлт амжилттай илгээгдсэн бол **Хүлээн аваагүй** төлөвтэй харагдана.

Хүлээн авсан

Татгалзсан
/ирсэн тайлбарын дагуу засвар оруулан дахин илгээх боломжтой/

Төлбөр болон анхааруулга

Шалгалтад тэнцсэн тохиолдолд

Та шалгалтад тэнцсэн бол 5 хоногийн дотор дараах материалыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн II байрны 212 тоот өрөөнд хүлээлгэн өгнө. Хэрэв материал бүрдүүлж өгөөгүй тохиолдолд таны зөвшөөрлийн гэрчилгээ **гарахгүй болохыг анхаарна уу**.

1. 3х4 хэмжээтэй цээж зураг 1 хувь /сүүлийн 2 сарын хугацаанд авахуулсан эгц урдаас харсан, албан хувцастай/
2. Тэмдэгтийн хураамж төлөх. 5,000 төгрөг /2 жилийн төгсөгч эмч нар 10,000 төгрөг/

Тэмдэгтийн хураамжийг ЭМХТ-ийн I, II-дугаар байрны нэг давхарт байрлуулсан төхөөрөмжид карт уншуулж төлж болохоос гадна https://itax.mta.mn вэб сайтруу орж төлбөрийн даалгавар үүсгэн 13-15 оронтой нэхэмжлэлийн код авна. Дурын банканд нэхэмжлэлийн 13-15 оронтой дугаарын дагуу тэмдэгтийн хураамжаа төлнө. Төлбөрийн даалгавар үүсгэхдээ дараах цэнхэр сонголтуудыг сонгоно.

- *Эрүүл мэндийн тухай хуулийн 25.3.1-д заасан зөвшөөрөл бүхий 2 жилийн лицензтэй эмч нар нь эхний жил өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт, хоёр дах жил үүнээс гадна аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, түргэн тусламжийн төвд их эмчээр ажилласан байх ёстой гэсэн шаардлагыг хангасан тохиолдолд 5 жилийн эрх хүсэх боломжтой. /Эрүүл мэндийн сайдын 2015 оны 98 дугаар тушаалын I хавсралт 1.7 зүйл/*

Цээж зураг, тэмдэгтийн хураамжийг шуудангаар явуулж болно. Зургийн хамт овог нэр, регистерийн дугаар, утасны дугаар, шалгалт өгсөн огноо, дүнг гаргацтай бичиж явуулах

Тэмдэгтийн хураамж төлсөн баримтаа **“Дүйцүүлэх материал”** хэсгийн харгалзах сонголтод PDF файл болгон оруулна.

Лиценз| Лицензтэй боллоо.

Та өмнөх хуудаст байгаа бүрдүүлэх материалыг бүрэн илгээснээр таны лицензийн хүсэлт баталгаажиж та цахим лицензтэй болох юм. Таньд амжилт хүсье!

Таны лицензийн хүсэлтийг хүлээн аваад, сайдын тушаал гарсны дараа “Эрүүл Мэндийн Хөгжлийн Төв”-өөс сайдын тушаалын дугаарыг оруулснаар та Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй /лиценз/ болох юм.

Лицензийн дугаар дээр дарснаар хэвлэх боломжтой зурган байдлаар харагдана.

Хэвлэх товч даран хэвлэж авах боломжтой. QR кодыг уншуулан цахим лицензийг харж болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Заавартай бүрэн танилцсан
танд баярлалаа

ТАНЫ МЭДЭЭЛЭЛ
ҮРГЭЛЖ
ТАНЬТАЙ ХАМТ.

www.hr.hdc.gov.mn